



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/ЧО

Булган сум

Г Гэрээ байгуулах эрх олгох тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” Төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүүжилтээр хэрэгжих “Бугат болон Хангал сумдын спорт заалны засвар”-ын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу 1 дүгээр багц Бугат сумын спорт заалны засварын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Арвайнцамхаг” ХХК-тай 249,551,844 (хоёр зуун дөчин есөн сая таван зуун тавин нэгэн мянга найман зуун дөчин дөрөв) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн), тус хөрөнгийг холбогдох хууль, журам, гэрээний дагуу хүлээн авч данс бүртгэлд бүртгэн, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга)-т тус тус үүрэг болгосугай.


3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Арвайнцамхаг” ХХК-ийн захирал (Ц.Цэрэндорж)-д даалгасугай.

4. Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг 1 дүгээр хавсралтаар, тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн ажилчид, машин механизмын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.


5. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу “Эрдэнэт үйлдвэр” Төрийн өмчит үйлдвэрийн газрын хамтын ажиллагааны гэрээний санхүүжилтээр санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д. ДҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2026 оны  
06 дугаар сарын 23-ны/ний өдрийн  
А/НО дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадлашгүй ажил	4,333,250	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
2	Захиалагчийн техник хяналтын зардал	4,333,250	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	2,166,625	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
4	Нормчлолын сан	389,992	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
5	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Эрдэнэбилэг (Аймгийн Засаг даргын тамгын газар)
6	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Д.Эрдэнэбилэг (Аймгийн Засаг даргын тамгын газар) Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
7	Гүйцэтгэлийн баталгаа	3 хувь	Д.Эрдэнэбилэг (Аймгийн Засаг даргын тамгын газар)
8	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 77 хоног	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)

--o00o--

А/НЧО Аймгийн Засаг даргын 2026 оны  
06 дугаар сарын 23-ны/ний өдрийн  
... дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



Тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн  
ажилчид, машин механизмын жагсаалт

Инженер, техникийн ажилчид			Хариуцах албан тушаалтан
д/д	Албан тушаал	Ажилтны нэр	
1	2	3	4
1	Барилгын инженер	Г.Сэрээжав	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
2	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	Д.Хулан	
Машин механизмын жагсаалт			Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
д/д	Машин механизмын нэр	Улсын дугаар, хэмжээ	
1	Автокран	1664 УБЧ	
2	Ачааны автомашин-1	8585 ӨВЕ 1212 ӨВА	

--o00o--